



Эрхэм таны энэ өдрийн амрыг эрэн мэндчилье.

Дэлхийн ойн өдөрт зориулан уламжлал болгон зохион байгуулдаг

“МОНГОЛ ОРНЫ ОЙН САЛБАРЫН БОДЛОГО, ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ”

сэдэвт үндэсний 2-р хурал 2017 оны 3 сарын 21 өдөр болно.

Санаачлан зохион байгуулагч: МУИС, БОАЖЯ, ОСХТ

Хамтран зохион байгуулагч: НҮБ-ХХААБ, ГОУХАН, НҮБ-REDD, ШУТИС, ХААИС, ОУУИС

Ивээн тэтгэгч байгууллага: БОАЖЯ, НҮБ-ХХААБ, ГОУХАБ, НҮБ-REDD, МУИС-ХШУИС

Энэхүү хурал нь үндсэн хуралдааны илтгэлүүд (5 илтгэл)-ээс гадна, доорхи асуудлын хүрээнд 24 илтгэлийг зохион байгуулах комиссоос урьдчилан шалгаруулж салбар хуралдааны хэлэлцүүлэгт оруулна. Үүнд

Салбар хуралдаан-1: Ойн экосистем ба менежментийн асуудалд

Салбар хуралдаан-2: Нөхөн сэргээлт, газар ашиглалт, хотын ногоон байгууламж, техник технологи

Салбар хуралдаан-3: Ой ба нийгэм-эдийн засгийн харилцаа

Тусгай хуралдаан: Ой хамгаалал – Ойн эрүүл ахуй

Тусгай хуралдаан: Ой, хээрийг түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохицуулах үндэсний зөвлөлийн хуралдаан

Тусгай хуралдаан: “Оройн нахиа” Оюутны Эрдэм шинжилгээний хурал

Жич: Салбар хуралдааны сэдвийн агуулгатай холбоотой санал, хүсэлтийг хүлээн авна.

Хуралд хэлэлцэгдэх аман илтгэл, ханын илтгэлийн хураангуйг (250 үгэнд багтаана уу) **2017 оны 3-р сарын 10-ны 12.00** цагаас өмнө

byambagerel@seas.num.edu.mn хаягаар ирүүлнэ үү.

Эсвэл доорхи линкээр орж бүртгүүлнэ үү

<https://goo.gl/forms/uAA8HcjnIF37A1cu2>

Сонгогдсон аман илтгэл болон ханын илтгэлийн (өгүүллийн) хялбаршуулсан хэлбэрийг (extended abstract) **2017 оны 3 сарын 17 өдөр** хүртэл, мөн дээрхи емэйл хаягаар хүлээн авах бөгөөд хурлын эмхэтгэлд оруулан хэвлэх тул та бүхэн хугацаандаа өгнө үү

Хуралд Их дээд сургуулийн магистрант, докторантуудыг ханын илтгэлийн хэлбэрээр судалгааны ажлаа хэлэлцүүлэхийг дэмжих бөгөөд дээрхийн адил бэлтгэгдсэн ханын илтгэлийн дэлгэрэнгүй хураангуйг хурлын эмхэтгэлд хэвлүүлнэ.

Илтгэлийн (өгүүллийн) дэлгэрэнгүй хураангуй нь доорх агуулгыг илэрхийлж байвал зохино:

- Судалгааны ажлын зорилго
- Шийдвэрлэсэн асуудал, түүний онол практикийн ач холбогдол
- Шинэлэг, дэвшүүлж санал
- Илтгэл (өгүүлэлд) доорх үндсэн шаардлага тавигдана:
- Эрдэм шинжилгээний өгүүлэл бичилтийн өнөөгийн түвшин, тавигдах шаардлагыг олон талаас нь судалгаа, баримтанд тулгуурлан дүн шинжилгээ хийсэн байх,
- Дүгнэлт, дэвшүүлсэн санал, зөвлөмж нь онол, практикийн ач холбогдолтой, шинэлэг байх,
- Энд хавсаргасан эрдэм шинжилгээний өгүүлэл бичих зааврыг баримтлах,
- Бичиглэлийн дүрэм, техник алдаагүй байх зэрэг болно.

Хурлын зохион байгуулалттай холбоотой асуудлаар:

Б.Оюунсанаа: oyunsanaa@seas.num.edu.mn утас 9908-1104

Н.Батхүү: batkhuu@seas.num.edu.mn утас 9192-3933

С.Бямбагэрэл byambagerel@seas.num.edu.mn утас 96658017 холбоо барина уу.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС
2017 оны 2-р сарын 22